



ХЭНТИЙ АЙМГИЙН
ДЭЛГЭРХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 1/52

Дэлгэрхаан сум

Ногоон зурвас байгуулахад хөрөнгө
зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6 дахь заалт, 30 дугаар зүйлийн 30.3 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 12 дугаар сарын 19-ны 23 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын ногоон байгууламжийн төлөвлөгөөний зураглалын дагуу авто зам дагуу ногоон зурвас байгуулах ажлыг зохион байгуулж хөрөнгийг зарцуулсугай.

2.Ногоон зурвас байгуулахад шаардагдах 3,615,000 (гурван сая зургаан зуун арван таван мянга) төгрөгийн зардлыг "Цагаан-Уул төгөл" хязгаарлагдмал хувьцаат компаний дансанд шилжүүлсүгэй.

3.Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зорилгоор төлөвлөгдсөн ажлын хүрээнд, амьдрах чадвар сайтай хөрсөн тохирсон тарьц суулгацыг нийлүүлж, бүрэн хашаажуулах ажлыг "Цагаан-Уул төгөл" хязгаарлагдмал хувьцаат компанийн захирал (Н.Бат-Өлзий)-д, ногоон байгууламжийг бий болгож ажиллахыг байгаль хамгаалагч (Х.Мөнхбат)-д, хяналт тавьж ажиллахыг байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (У.Ариунтуяа)-д үүрэг болгосугай.

4.Дээрх ажилд шаардагдах хөрөнгийг холбогдох иргэдийн дансанд шилжүүлэхийг Засагт даргын Тамгын газрын нягтлан (О.Анхцэцэг)-т, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Д.Батнасан) нарт даалгасугай.

ДАРГА



Б.ЭНХ-АМГАЛАН

2376010103

